

Долдугаар бүлэг

Эрүүгийн хэргийн талаар эрхийн

туслалиаа үзүүлэх, шилжүүлэн

өгөх

I. Эрхийн туслалиаа

Жаран зургадугаар зүйл

Эрхийн туслалиаа үзүүлэх

1. Энэхүү Гэрээнд дурдсан нөхцөлд Хэлэлцэii Тохирогч хоёр Этгээдийн шуух бие биедээ эрхийн туслалцаа харилцан үзүүлэх уурэг хүлээнэ.

2. Гэрээний экэ бүлэгт дурдсан шуух гэдэг ойлголтод еөрийн улсын дотоодын хуулиар эруугийн хэрэг авч хэлэлцэх " зрх бүхий Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн бусад байгууллагыг нэг адил хамааруулна.

Жаран долдугаар зүйл

Эрхийн туслалцаагы хэмжээ

Эруугийн хэргийн талаар үзүүлэх эрхийн туслалцаанд бичиг баримт, баталгаа гардуулах, туунчлэн яллагдагч, гзрч, шинжээч нарыг байцаах, шуухийн мөрдөн байцаалт явуулах, шинжээч томилохыг шаардах, байрны болон хувийн нэгжлэг хийх зэрэг байцаан шийтгэх зарим ажиллагааг багтаана.

Жаран наймдугаар зүйл

Харилцах журам

Эруугийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэхдээ энэхүү Гэрээний 9-18 дугаар зүйлийн зохих заалтыг хэрэглэнз.